



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 4320

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 4, 72 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 238 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь хэсэг, аймгийн Засаг даргын Удирдлагын Зөвлөлийн 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 09 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг орон нутагт 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс, 2026 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хооронд зохион байгуулагдахад шаардагдах зардалд санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг зохион байгуулахад зарцуулагдах 27,000,000 (хорин долоон сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Насанбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны 08 дугаар сарын  
08-ны өдрийн 50 дугаар захирамжийн хавсралт

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН 2026 ОНЫ УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫГ 18  
СУМ, 2 ТОСГОН, 80 БАГТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

| №        | Эдийн засгийн ангиллын код | Зардлын төрөл                    | Тоо хэмжээ                     | Нэг бүрийн үнэ /төгрөгөөр/ | Нийт дүн /төгрөгөөр/ |
|----------|----------------------------|----------------------------------|--------------------------------|----------------------------|----------------------|
| 1        | 210402                     | Тээвэр, шатахууны зардал         | 1250 литр                      | 3,200.00                   | 4,000,000.00         |
| 2        | 210702                     | Дотоод албан томилолтын зардал   | 10 албан хаагч 20 хоног        | 90,000.00                  | 18,000,000.00        |
| 3        | 210901                     | Бараа, үйлчилгээний бусад зардал | 1 барилга, 8 тээврийн хэрэгсэл | -                          | 5,000,000.00         |
| Нийт дүн |                            |                                  |                                |                            | 27,000,000.00        |